

---

# ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХҮЧИРХИЙЛЭЛ

ХОТЫН ЗАХЫН ДҮҮРЭГТ ХИЙСЭН  
КЕЙС СУДАЛГААНЫ ТАЙЛАН

---



ЗАЛУУЧУУДЫН ДУНДАХ ХУЧИРХИЙЛЭЛ  
ХОТЫН ЗАХЫН ДҮҮРЭГТ ХИЙСЭН КЕЙС  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Энэхүү судалгааг Нээлттэй Нийгэм Форумын арга зүйн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр Бодлогод залуусын хяналт ТББ судлаачид хамтран гүйцэтгэв.

Судлаачид:

---

Ц.Мандхайхатан

Н.Должин

У.Ганбаяр

Ш.Гэгээн-Оргил

Гэрэл зургийг: Н.Түвшин

© Нээлттэй Нийгэм Форум, 2015

Уг кейс судалгааг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

DDC

370

3-236

ISBN-978-99973-63-98-5

# АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар .....	4
Удиртгал .....	5
Судалгааны зорилго, зорилт .....	6
Судалгааны арга зүй.....	6
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Залуучуудын дундах хүчирхийлэл нийгмийн асуудал болох нь .....	8
ХОЁРДУГААР БҮЛЭГ. Залуучуудын амьдралд тохиолдсон хүчирхийлэл: Налайх дүүргийн кейс .....	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ. Залуучуудын дундах хүчирхийллийн илрэх хэлбэр, нийтлэг шалтгаан .....	22
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Хүчирхийлэл гарахад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийн дүн шинжилгээ .....	25
ТАВДУГААР БҮЛЭГ. Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга стратеги .....	28
Ашигласан материал.....	32

## Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНУ-ын ӨХТ	АНУ-ын Өвчлөлийг хянах төв
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага

# Удиртгал

Дэлхийн хэмжээнд олон залуу хүний амь нас, эрүүл мэнд, сайн сайхан байдалд заналхийлж байдаг хүчирхийлэл рүү хөтөлдөг хувь хүн, гэр бүл, орчин хүрээлэл, нийгмийн хүчин зүйлсийг нухацтай судлан бодлого, хөтөлбөр боловсруулахад өргөнөөр ашиглаж байна. Судалгаанд суурилсан мэдлэгтээ үндэслэн төрөл бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг багасгах стратеги, хөтөлбөрөөр дамжуулан хүчирхийллийг гарахаас нь өмнө урьдчилан сэргийлэх, даамжрахаас нь өмнө таслан зогсоох ажил хийгдэж байна. Манай улсын хувьд энэ төрлийн хүчирхийлэл гарахад хүргэж буй шалтгаан нөхцөлийг судалж, нэгтгэн дүгнэснээ ашиглан урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх ажил үгүйлэгдэж байна. Иймд залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах бодлогын орчин, хэрэгжүүлэх туршлага бий болгоход оролцох нь Бодлогод залуусын хяналт ТББ-ын эрхэм зорилго, үүрэг гэж үзэн залуучуудын дундах хүчирхийллийг бууруулах замаар нийгэм дэх хүчирхийллийг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилготой энэхүү төслийг хэрэгжүүлээ.

Залуучуудын дундах хүчирхийллийн асуудлыг залуучууд байгаа газар бүрт судлан тодорхойлж, урьдчилан сэргийлэх стратеги, хөтөлбөрүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх ёстой ч бидний хувьд энэ асуудлаар улс даяар, өргөн хэмжээний судалгаа явуулах боломжгүй учир тодорхой орон нутаг буюу Налайх дүүргийг сонгон дүүргийн нэг хороо, МСҮТ, ерөнхий боловсролын нэг сургуулийг хамруулан мэдээлэл цуглуулсан юм. Нийслэлээс 36 км алслагдсан Налайх дүүрэг нь 2013 оны байдлаар 33,235 хүн амтай, түүний 25 хувь нь 15-24 насныхан байв. ЕБС-ийн 7 сургуульд 6000 гаруй хүүхэд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 1200 гаруй хүүхэд суралцдаг. Налайхын уурхайг түшиглэн үүссэн учраас “уурхайчдын хот” гэж нэрлэгдэж ирсэн энэ дүүрэгт 1990 оноос хойш уурхай хаагдсаны улмаас ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийгмийн хүндрэлтэй асуудлууд хурцаар тавигдах болжээ. Мөн тус дүүрэг шилжин суурьшигч ихтэй, үндэсний цөөнх болох казах иргэд олонтой, дүүргийн МСҮТ-д хотын бусад дүүрэг, аймгаас залуучууд ирж суралцдаг зэрэг онцлогтой юм.

Налайх дүүрэгт хийсэн энэхүү кейсийн судалгаа нь залуучуудын дундах хүчирхийллийн төрөл хэлбэр, хүчирхийлэл гарахад нөлөөлж байгаа хүчин зүйлсийг илрүүлж тогтооход чиглэсэн болно. Судалгааны үр дүнд олж авсан мэдээллээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), АНУ-ын Өвчлөлийг хянах төв (АНУ-ын ӨХТ) зэрэг хүчирхийллээс сэргийлэх асуудлаар ажилладаг нэр хүнд бүхий байгууллагуудын мэдээллийн сан, туршлага, зөвлөмжид тулгуурлан судалж орон нутгийн түвшинд авч хэрэгжүүлж болох бодлого, хөтөлбөрт тусгахуйц зөвлөмжийг боловсрууллаа.

Уг судалгааг Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-ын арга зүйн болон санхүүгийн дэмжлэгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн эрдэмтэн багш Б.Ариунсанаа арга зүйн зөвлөхөөр ажиллав. Судалгааны багт Ц.Мандхайхатан, Н.Должин, У.Ганбаяр, Ш.Гэгээн-Оргил нар ажилласан болно.

### Судалгааны зорилго, зорилт

Залуучуудын дунд гарч буй хүчирхийллийн шалтгаан нөхцөл, үр дагавар, урьдчилан сэргийлэх арга замын талаар мэдлэг бий болгоход хувь нэмрээ оруулах нь энэ судалгааны зорилго юм.

Энэ зорилгоо хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно:

- 1) Тодорхой нэг орон нутагт 15-24 насны залуучуудын дунд гарч буй хүчирхийллийн кейсүүдийг баримтжуулж, нарийвчилсан мэдээлэл цуглуулах;
- 2) Цуглуулсан кейсийн мэдээлэлдээ дараах хоёр чиглэлээр дүн шинжилгээ хийх:
  - Хүчирхийллийн тохиолдол бүрт нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоох;
  - Олон улсын судалгааны эх сурвалжуудад тулгуурлан ижил төстэй нөхцөлд залуучуудыг хүчирхийллээс хамгаалах хүчин зүйлсийг судалж тогтоох;
- 3) Ийнхүү дотоодод хийсэн кейсийн судалгаа, гадаад эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой стратеги, үйл ажиллагааны чиглэлүүдийг санал болгох.

### Судалгааны арга зүй

Энэ судалгаагаар *“Залуучуудын дунд хүчирхийлэл гарахад ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?”* гэсэн гол асуултыг тавилаа. Энэ хүрээнд эхлээд холбогдох тоо баримт, дотоодын болон олон улсын мэдээлэлд үндэслэн залуучуудын хүчирхийллийн талаарх өнөөгийн бидний ойлголт хандлагыг судалж, дараа нь кейсийн судалгааны арга зүйг ашиглан тодорхой нэг орон нутаг дахь залуучуудын дунд гарч буй хүчирхийллийн тохиолдлуудыг нарийвчлан судалж, эцэст нь олон улсын түршлагад тулгуурлан урьдчилан сэргийлэх стратеги, хөтөлбөрийн холбогдолтой зөвлөмж боловсрууллаа.

Кейсийн судалгаанд хүчирхийллийг тодорхойлохдоо “гэмт хэрэг” гэсэн эрүүгийн эрх зүйн нэр томьёо, энэ салбарын мэдлэгт тулгуурлаагүй болно. Харин нийгмийн эрүүл мэндийн салбарын зан үйлтэй холбоотой шалтгаан, үр дагаврын хандлагыг баримтлалаа.

Судалгааны мэдээллийг баримт бичгийн судалгаа болон ярилцлагын аргаар цуглуулсан.

- *Баримт бичгийн аргыг* олон улсын болон дотоодын судлаачдын судалгаа, тоо баримт, залуучуудын дундах хүчирхийллийн талаарх үндсэн мэдээллийг цуглуулахад ашиглав. Харин чанарын мэдээлэл буюу хүчирхийллийн тодорхой кейсүүдийг цуглуулахад ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглав. Үүнд:
- *Ганцаарчилсан ярилцлагыг* хоёр сэдвээр нийт 25 удаа явуулсан бөгөөд нэг удаагийн ярилцлага 20-40 минут үргэлжилсэн. Эхний сэдэв нь сургуулийн орчинд гардаг хүчирхийллийг илрүүлэх зорилготой байсан учир сургууль тус бүрийн нийгмийн ажилтан, багш, эцэг эхийн төлөөлөл, цагдаагийн ажилтан, дүүргийн сэтгэл зүйч, сурагч, оюутны төлөөллийг оролцуулсан. Хоёр дахь сэдэв нь залуучуудын амьдарч байгаа хорооны нутагт гарч буй хүчирхийллийг илрүүлэх зорилготой байсан ба хорооны нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан, иргэд буюу дэлгүүрийн худалдагч, РС тоглоомын газар ажиллуулагч, худгийн ажилтан, залуусын төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Мөн хорооны залуусыг нэг дор цуглуулах боломжгүй байсан учир айлаар явах, худаг дээр дугаарлаж буй залуустай ярилцах зэргээр санамсаргүй байдлаар оролцогчдыг сонголоо.
- *Фокус бүлгийн ярилцлагыг* ЕБС болон МСҮТ дээр зохион байгуулсан бөгөөд нийт 17 удаагийн ярилцлагад 110 оюутан сурагч оролцов. Охид, хөвгүүдийн бүлэгтэй тусад нь ярилцсан бөгөөд 60-90 минут үргэлжилсэн нэг удаагийн ярилцлагад 7-9 сурагч оролцов. ЕБС дээр нийт 8 фокус бүлгийн ярилцлагад 10-12-р ангийн 45 сурагч, МСҮТ дээр нийт 9 удаагийн ярилцлагад 1, 2-р курсийн оюутнууд, Оюутны зөвлөлийн гишүүдийн төлөөлөл зэрэг 65 хүнийг хамрууллаа.

Нэгдүгээр бүлэг

---

Залуучуудын дундах хүчирхийлэл  
нийгмийн асуудал болох нь





Хүчирхийлэл нь хүүхэд, залуусыг стресст оруулах, архи, мансууруулах бодис, тамхи хэрэглэх, амь насаа алдах, амиа хорлоход хүргэдэг<sup>1</sup> ноцтой хор уршигтай нийгмийн үзэгдэл юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Амь насаараа хохирох, бие махбодь болон сэтгэлзүйн гэмтэл авах, хөгжлөөр хоцрох, гачигдалд өртөх зэрэг ноцтой үр дагаварт хүргэдэг хувь хүн, бүлэг, олон нийтийн<sup>2</sup> эсрэг биеийн хүч, эрх мэдлээ санаатайгаар ашигласан, ашиглахаар заналхийлсэн үйлдлийг хүчирхийлэл гэнэ”<sup>3</sup> гэж тодорхойлсон байдаг. Дэлхий даяар нас баралт, хөгжлийн бэрхшээлийн нэг гол шалтгаан болоод байгаа хүчирхийллийн улмаас жил бүр 1,6 сая хүн нас барж байгаагийн 54 хувь нь амиа хорлон, 35 хувь нь бусдын гарт амиа алдаж, 11 хувь нь дайн, зэвсэгт мөргөлдөөн зэрэг бүлгийн хүчирхийлэлд өртөж<sup>4</sup> байна.

Монгол Улс залуучуудын орон болоод байгааг 2010 оны хүн амын тооллогын дүн баталсан. Нийт 2 сая 700 мянга гаруй хүнтэй манай улсын 20,7 хувь нь НҮБ-ын тодорхойлсноор “залуу үе” болох 15-24 насныхан<sup>5</sup> байгаа ба 25-34 насны залуус манай нийт хүн амын 17,8 хувийг<sup>6</sup> эзэлж байгаа нь Монголыг ажиллаж бүтээх, сурч хөгжих насны томоохон нөөц, хүчин чадалтай улс гэж харах үндэслэл болж байна. Гэтэл манай улсад хийсэн үндэсний хэмжээний судалгаагаар “дөрвөн сурагч тутмын нэг нь хүчирхийлэлд өртдөг,”<sup>7</sup> “6-11-р ангийн ангийн сурагчдын 98,6 хувь нь сургуулийн орчинд ямар нэгэн төрлийн хүчирхийлэлд өртдөг” ба үйлдэж буй гол субъект нь юуны өмнө үе тэнгийнхэн нь байдаг<sup>8</sup> ажээ. Мөн 2014 онд 18-24 насны 140 залууг оролцуулан хийсэн судалгаанд 31,4 хувь нь бие махбодийн хүчирхийлэлд, 38,8 хувь нь сэтгэл зүйн хүчирхийлэлд, 21.5 хувь нь бэлгийн хүчирхийлэлд сургууль болон ажлын байрандаа өртөж байжээ<sup>9</sup>.

<sup>1</sup> Эрүүл мэндийн яам ба бусад, “Дэлхий дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа- Монгол 2010: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох.”(Улаанбаатар хот, 2011 он) 47 тал.

<sup>2</sup> Тайлбар: Энэхүү тодорхойлолтод өөрийнхөө эсрэг хүч хэрэглэхийг хүчирхийллийн ойлголтод хамааруулж үзсэн. Жишээ нь амиа хорлох, биеэ зүсэж тайвшрах зэрэг нь энэ ойлголтод хамаарна. Уншигчдад эргэлзээ төрүүлэхгүйн үүднээс болон энэхүү судалгаанд энэ ойлголтыг хөндөхгүй учир тодорхойлолтод оруулалгүй, тусад нь тайлбарлалаа.

<sup>3</sup> Албан бус орчуулга. <http://www.who.int/violenceprevention/approach/definition/en/>

<sup>4</sup> World Health Organization, “Preventing Violence and Reducing its Impact: How Development Agencies Can Help” flyer:<http://www.who.int/violenceprevention/publications/Flyer.pdf?ua=1>

<sup>5</sup> ХАХНХЯ, НҮБ-ын хүн амын сан, “Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогын зөвлөмж.”(Улаанбаатар хот, 2013 он) 15-р тал

<sup>6</sup> “2010 оны Хүн ам, орон сууцны тооллого.” (Улаанбаатар хот, 2011 он) 183-р тал


<sup>7</sup> Эрүүл мэндийн яам ба бусад, “Дэлхий дахины сургууль суурилсан эрүүл мэндийн судалгаа- Монгол 2010: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох.”(Улаанбаатар хот, 2011 он). 51-р тал.

<sup>8</sup> БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам” судалгааны тайлан. Улаанбаатар хот 2007 он, 14 болон 68-р тал.

<sup>9</sup> Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, “Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа - 2014.” 30-р тал.

Нөгөө талаас, ноцтой байдалд хүрч хүндэрсэн хүчирхийлэл нь хохирогч болон үйлдэгчийн амьдралд сөрөг нөлөө үзүүлдэг. 2011 онд 8210 хүн, үүнээс 14-29 насны 4815 хүн (58.6 хувь) шүүхээр ял шийтгүүлжээ. Тэдний үйлдсэн гэмт хэргийн улмаас 18,592 хүн хохирсноос 1189 нь 18 хүртэлх насны, 9624 нь 18-35 насны хүн байгаа нь нийт хохирогчдын 58 хувь болж байна. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төвийн тайланд 2010 онд насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг 455 бүртгэгдсэнийг тэмдэглэжээ. Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилан дараах графикт харуулав.

График 1. 2010 онд бүртгэгдсэн насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэргийн тоон мэдээлэл (Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл, судалгааны төвийн тайланд дурдсанаар)



Түүнчлэн насанд хүрээгүй хүмүүс оролцсон **455 хэрэгт 907 хүүхэд** холбогдон шалгагдсан нь өмнөх оныхоос 3.8 хувиар буурчээ. Тэдний 38 нь согтуу байх үедээ, 151 нь бүлэглэн хэрэг үйлдсэн байна. Түүнчлэн 26 нь урьд ял шийтгэгдсэн хүүхдүүд байсан бол 35 нь эмэгтэй, 456 нь сурагч, 87 нь оюутан, 42 нь сургууль завсардсан, 10 нь тэнэмэл амьдралтай, 1 нь хоригдол, 233 буюу 25.7 хувь нь 14-15 насны, 674 буюу 74.3 хувь нь 16-17 насныхан байв. Тэдний үйлдсэн гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 165 хүн гэмтэж, иргэд байгууллагад 233.5 сая төгрөгийн хохирол учирсан”<sup>10</sup> гэжээ. Дээрх статистикаас

харахад гэмт хэрэгт холбогдсон сурагч, оюутны тоо өндөр байгаа ба согтуугаар болон бүлэглэн гэмт хэрэг үйлдэх нь цөөнгүй байна.

Манай улсын хувьд ид сурч хөгжих, ажиллаж бүтээх насандаа залуучууд хүчирхийлэлд багагүй өртөж байгаа нь өнөөдөр цөөн хэдэн хүний асуудал гэж хандаж болохооргүй, хүн амын томоохон бүлгийг хамарсан нийгмийн асуудал болсон гэж үзэх үндэслэл байна.

Дэлхий нийтээр залуучуудын дундах хүчирхийллийг сүүлийн 30 жилд эрчимтэй судалж байгаагийн хүчинд нийгмийн эрүүл мэнд, эрүүгийн эрх зүй, нийгмийн ажил, сэтгэл судлалын салбарт багагүй мэдлэг хуримтлагдаад байгаа ажээ. Энэ их ажлын үр дүнд хүчирхийлэл бол хувь хүний төрөлхийн шинж чанар гэхээс илүүтэй янз бүрийн хүчин зүйлийн нөлөөгөөр бий болдог, төлөвшдөг хандлага, зан үйл юм гэсэн ойлголт бүрдээд байна. Улмаар хэвшсэн зан үйлийг өөрчилж болохоос гадна сөрөг зан үйлийг хэвшихээс нь өмнө урьдчилан сэргийлж болдог гэж үздэг нийгмийн эрүүл мэндийн хандлага улам бүр хүчтэй болж байна.

Залуучуудын дундах хүчирхийлэлд хүргэж байгаа хүчин зүйлсийг судлаачид янз бүрээр ангилж, бүлэглэж үздэг ба хамгийн нийтлэг нь хувь хүн, гэр бүл, орчин хүрээлэл, нийгмийн гэсэн дөрвөн түвшний эрсдэлт хүчин зүйлстэй холбож үздэг байна.<sup>11</sup> Тэд мөн эрсдэлт хүчин зүйл гэдэг нь тодорхой тохиолдолд шууд үйлчлэх шалтгаан биш харин давтамжид үндэслэсэн магадлалт нөхцөл гэдгийг онцолдог. Эрсдэлт хүчин зүйлийн нөлөөнд байгаа залуу хүн бүр хүчирхийлэл үйлдэнэ гэсэн үг биш, харин эдгээр нөхцөл байдал нь өмнө олонтаа юмуу байнга илэрч байсан гэсэн үг юм. Нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэн судлах нь урьдчилан сэргийлэх хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөхөд тус болдог байна.

*Хувь хүний хүчин зүйлсд* тухайн хүний амьдралын туршлага, зан чанар, зан үйл зэргийг багтаажээ. Жишээлбэл:

- өмнө нь хүчирхийллийн хохирогч болж байсан
- анхаарал төвлөрөл сул, хэт хөдөлгөөнтэй эсвэл суралцах идэвхгүй
- бага насандаа уур бухимдал гаргаж байсан
- хар тамхи, архи болон тамхи хэрэглэдэг
- аливаа зүйлд дүн шинжилгээ хийх, үйлдэлдээ дүгнэлт өгөх чадавх сул, үйлдлээ хянах чадвар муутай

<sup>10</sup> Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, судалгааны төв, “Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам.” (Улаанбаатар хот, 2011 он) 82-83-р тал

<sup>11</sup> Албан бус орчуулга. ДЭМБ-аас гаргасан “Хүчирхийлэл ба эрүүл мэндийн дэлхийн тайлан,” CDC “Preventing Youth Violence: Opportunities for Action” (June 2014) болон [www.cdc.gov](http://www.cdc.gov) сайтаас дэлгэрүүлж үзнэ үү.

- сэтгэл гутралд орсон, сэтгэл зүйн эмчилгээ хийлгэж байсан
- хүчирхийлэл, зөрчилтэй гэр бүл, орчинд амьдардаг
- нийгмийн хэв журам, эв нэгдлийн эсрэг итгэл үнэмшил, хандлагатай байх.

*Гэр бүлийн түвшний эрсдэлт хүчин зүйлс* гэдэгт өсвөр насныхан түүний гэр бүл, эцэг эх, үе тэнгийнхэн болон бусад талуудтай харилцах харилцааны нөлөөллийг авч үздэг байна. Жишээлбэл:

- гэр бүл нь хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхдээ захиргаадлын арга барилаар ханддаг, хүмүүжлийн хатуу ширүүн, эсвэл хэт сул, эсвэл хааяа хатуу, хааяа зөөлөн зэргээр тууштай бус хандлага баримталдаг
- хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн оролцоо бага байх
- эцэг эх, асран хамгаалагчид сэтгэл зүйн хувьд хүүхдэдээ хайхрамжгүй ханддаг
- эцэг эх нь хүчирхийлэгч байх, гэр бүл доторх үүрэг хариуцлага сул, хүүхдээ харж хандах, зөвлөн дэмжихэд анхаарал бага байх.

*Орчин, хүрээллийн түвшний эрсдэлт хүчин зүйлс* гэдэгт тухайн залуу хүний амьдарч буй орон нутгийнх нь онцлог, орчин хүрээлэл, үе тэнгийнхний дунд хэвшсэн зан үйлүүдийг багтаадаг байна. Жишээлбэл:

- үе тэнгийнхнийх нь дунд элдэв танхайн бүлэг, дээрмийн бүлэглэлүүд байдаг
- үе тэнгийнхэн нь тодорхой нэг хүүхдийг тусгаарлах, түүнтэй харилцахгүй байх
- орон нутаг нь эдийн засгийн нөөц боломж хязгаарлагдмал, эдийн засаг, нийгмийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй
- ядуурал ихтэй
- гэр бүл салалт ихтэй
- иргэдийн идэвх оролцоо сул, иргэд зохион байгуулалтад ороогүй, нэг хамт олон гэсэн хандлага бүрэлдээгүй зэрэг нь хүчирхийлэл гарахад нөлөөлдөг эрсдэлт хүчин зүйлс болдог байна.

*Нийгэм* нь хүчирхийллийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрөх хандлагатай, боловсролын болон эдийн засгийн үйл ажиллагаа явуулах боломж, дэмжлэг хязгаарлагдмал байх зэрэг нь нөлөөлдөг гэж судлаачид үзэж байна.

Дүгнэн хэлэхэд, хүчирхийлэл бол хувь хүн, гэр бүл, орчин хүрээлэл, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөгөөр төлөвшиж бүрэлддэг зан үйл тул энэ зан үйлд хүргэж байгаа хүчин зүйлсийг судалж тогтоосноор урьдчилан сэргийлэх боломжтой болох юм. Иймд манай улсын хүн амын томоохон хэсэг болж байгаа залуучуудын дундах хүчирхийллийг нийгмийн эрүүл мэндийн асуудал талаас нь судлах зайлшгүй шаардлагатай байна.

Хоёрдугаар бүлэг

Залуучуудын амьдралд тохиолдсон  
хүчирхийлэл: Налайх дүүргийн кейс



Дэлхийн хэмжээнд залуучуудын дунд зодолдох, дээрэлхэх<sup>12</sup> явдал нэлээд гардаг ба хөгжиж буй 40 улсад хийсэн судалгаагаар хөвгүүдийн 9-45 хувь, охидын 5-39 хувийг хамарсан нийтлэг үзэгдэл болохыг тогтоожээ.<sup>13</sup> Монголд ч, дэлхийд ч залуучуудын хувьд хүчирхийлэл үйлдэгч нь юуны өмнө үе тэнгийнхэн нь байдаг онцлогтой. Англи хэлт орнуудад “дээрэлхэлт” (bullying) гэж нэрлэдэг хүчирхийллийн энэ төрлийг Монголд “үе тэнгийн хүчирхийлэл” гэж нэрлэжээ. Судлаач С.Энхтуяа “Үе тэнгийнхний хүчирхийлэл гэдэг нь нэг болон хэсэг бүлэг сурагчид бусад хүүхдийн эсрэг бие махбодь болон сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэхийг хэлнэ. Үе тэнгийнхний хүчирхийлэлд шоглох, заналхийлэх, цохих, тохуурхах болон эд зүйлийг нь хулгайлах шүүд үйлдэл болон нэгнийхээ талаар цуу яриа тарааж тухайн сурагчийг нийгмээс тусгаарлагдахад нөлөөлөх шүүд бус үйлдлүүд орно”<sup>14</sup> гэжээ. 2013 онд Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хийсэн сургуулийн хүүхдийн эрүүл мэндийн зан үйлийн судалгааны “Осол гэмтэл, хүчирхийлэл” бүлэгт дээрэлхүүлэх гэсэн үзэгдэлд “нэг ба хэсэг сурагчид нөгөөдөө таагүй зүйл хэлэх, таагүй үйлдэл хийх, гадуурхах, шоглох”-ыг багтаасан ба нөхөрсгөөр тоглоом, шоглоом хийхийг оруулаагүй байна.<sup>15</sup>

Хүчирхийлэл нь хүүхэд, өсвөр үеийнхнийг бухимдуулах, архи, мансууруулах бодис, эм хэрэглэх, амиа хорлоход хүргэдэг гэж Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн дээрх судалгааны тайланд дурджээ. Амьдралын ийм сөрөг туршлагатай сургуулийн сурагчдын 30 орчим хувь нь сургууль дээрээ таарч байгаа ба “энэ нь сургуульд сурч буй 4 сурагчийн нэг нь бусдадаа гадуурхагдах, шоглуулах улмаар зодуулах зэрэг хүчирхийлэлд байнга өртөж байгааг харуулж байна” гэж уг тайланд дүгнэсэн байна.

Залуу насны эхэн үед буюу өсвөр насанд нийтлэг тохиолддог нэг нэгнээ дээрэлхэх хүчирхийллийн энэ хэлбэрийг бид уг судалгаагаар авч үзсэн. Судалгаанд 15-24 насны залуучуудын дунд сүүлийн 3 жилд гарсан тохиолдлуудыг хамрууллаа. Сургууль, гудамж талбай зэрэг орчинд нэг юм уу хэсэг, бүлэг залуус үе тэнгийн бусад залуусын эсрэг хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэх, нэр төрд нь халдах, үг хэлээр доромжлох, нэр хоч өгөх, ялгаварлан гадуурхсан үйлдэл, эс үйлдэхгүйг “дээрэлхэх төрлийн хүчирхийлэл” гэж ойлгох юм.

<sup>12</sup> Англи хэлний “bullying” гэсэн үгийг “дээрэлхэх” гэж орчуулсан.

<sup>13</sup> Албан бус орчуулга. Дэлгэрэнгүйг <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/> болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан “Хүчирхийлэл ба эрүүл мэнд дэлхийн тайлан”-гийн Залуусын хүчирхийлэл гэсэн хэсгээс үзнэ үү.

<sup>14</sup> D.Olweus, *Bullying at School: What We Know We Can Do* (Oxford, Blackwell, 1993). Дам ишлэв: С.Энхтуяа, “Хүүхэд хамгааллын үндэс.” Улаанбаатар 2009 он, 80 тал.

<sup>15</sup> Дэлхийн дахины сургуульд суурилсан эрүүл мэндийн судалгаа – Монгол, 2013

## Кейс 1:

Оюуны хөгжлийн бэрхшээлтэй охиныг гэрийнхээ орчимд ганцаараа тоглож байхад нь тухайн хорооны эрэгтэй хүүхдүүд “тэнэг, мангар” гэж хочлон дуудах, чулуу шидэх зэргээр уурлуулж, өдөх явдал байнга гардаг.

**Шалтгаан:** Хөвгүүд бүлгээрээ байх үедээ охиныг уурлахыг харж, хөгжилдөх гэж өддөг байна.

**Авсан арга хэмжээ:** Охиныг ганцаараа, хамгаалах хүнгүй байх үед энэ явдал гардаг тул эцэг, эх нь энэ хавийн эрэгтэй хүүхдүүд ингэдэг гэсэн төсөөллөөс өөр баримт байхгүй. Мөн эцэг эхийн хувьд шинэ жил, хүүхдийн баяраар бэлэг авахаас бусдаар хороондоо очдоггүй учир хороо, дүүргийн албан хаагчдад энэ байдлыг мэдээлж байгаагүй.

**Үр дагавар:** Охин эргүүлэн чулуу шидэх, уурлах зэргээр хариу үйлдэл үзүүлдэг. Уурлахаараа үйлдлээ хянаж чадахгүй болж, хэнийг ч хамаагүй цохих, зодох зэргээр биеэ барьж чаддаггүй, тайвшруулахад хэцүү байдаг. Охиноо хамгаалах үүднээс эцэг, эхийн аль нэг нь гэртээ заавал харж үлддэг ба энэ нь гэр бүлийн санхүүгийн байдалд нөлөөлдөг.

## Кейс 2:

МСҮТ-ийн хөвгүүдийн дунд “атаман” гэж нэрлэгддэг 21 настай залуу нэг сургуульд сурдаг хамаатны дүүгээ өмөөрч хүүхэд зодсон.

**Шалтгаан:** Хамаатны 14 настай дүү нь сагс тоглож байхдаа хөл дээр нь гишгэсний улмаас 3-р курсын хүүхдэд зодуулсан байсан. Дүүгээ өмөөрч очсон ба зодсон хүүхэд “Танай дүү чинь томроод байсан...” гэхээр нь хэд хэдэн удаа алгасан байна. Энэ үед багш ирж, зодооныг зогсоожээ.

**Авсан арга хэмжээ:** Дүүгээ өмөөрч хүн зодсон залууд сургуулийн зүгээс сануулах арга хэмжээ авсан. Гурван удаа сануулах хуудас авбал сургуулиас хөөгддөг тул тэрээр асуудал гаргалгүй төгсөхийг хичээж байгаа (үүнээс өмнө хэн нэгнийг дээрэлхэж байгаагүй гэж өөрөө хэлж байв). Дүүг нь зодсон хүүхдэд сургуулийн зүгээс ямар нэгэн арга хэмжээ аваагүй.

**Үр дагавар:** Энэ явдлаас хойш дүүг нь өөр хүн дээрэлхээгүй бөгөөд сургуульдаа сурч байгаа. Залуугийн хувьд зодсон хүүхэдтэйгээ дахиж муудалцаагүй. Харин дүүг нь дахин хүн дээрэлхвэл дахиад ингэхээс буцахгүй гэсэн хандлагатай байгаа нь асуудал бүрэн шийдвэрлэгдээгүйг харуулж байна.

### Кейс 3:

Өнгөрсөн жил МСҮТ-д Баганнуур дүүргээс ирж суралцаж байсан хүүхдийг Налайхын 20 гаруй залуу зодох гэж дотуур байр руу дайрч орсон байна.

**Шалтгаан:** Налайхын атаман гэж тооцогддог хүүхэдтэй сагс тоглож байхдаа мөрлөлөө гэж муудалцсан. Ингээд хоорондоо зодолдоод Багануурын хүүхэд дийлсэн байна. Налайхын хүүхэд өөрийн танил 20-иод залууг цуглуулж, нөгөө хүүхдийг зодох гэж ирэхэд нь сургууль руугаа зугтаж орсон тул яаж ч чадаагүй байна.

**Авсан арга хэмжээ:** Тухайн үед цугласан залуучуудыг багш нарын хүчээр тараажээ. Тэгээд хорооны цагдаад хандаж, цагдаа байцаалт авах, сануулах зэргээр арга хэмжээ авах гэж оролдсон боловч тодорхой үр дүн гараагүй.

**Үр дагавар:** Налайхын зодуулсан гэх хүүхэд өс санаж, боломж л гарвал зодох гэдэг болсон. Нийгмийн ажилтны хэлснээр “тухайн хүүхдийг зодож алчих гээд байсан учир аргагүйн эрхэнд ар гэрийнхнийг нь дуудан, нутаг буцаасан” байна. Ийнхүү нутгийн хүмүүстэй муудалцсан учир Багануурын хүүхэд сургуулиасаа гарч, мэргэжил эзэмшиж чадаагүй байна.

### Кейс 4:

15 настай охин ангийнхаа хөвгүүдтэй байнга хэрэлдэж, муудалцдаг. Нэг удаа ангийн хөвгүүнээ анги цэвэрлэж байх үеэр зодсон (алгадаж, цохьсон).

**Шалтгаан:** Түүнийг ангийнх нь хөвгүүн “янхан” гэж доромжилж, лифчикнийх нь товчийг тайлж, шоолсон. Доромжилсон утгатай нэр хоч өгөх, биед нь хүрэх зэргээр шоглох, хөгжилдөх зорилгоор элдвээр өдөх явдал байнга гарч байсан учир тэвчээр нь барагдаад ийм үйлдэл гаргасан гэж охин хэлсэн.

**Авсан арга хэмжээ:** Түүний энэ үйлдлийг багш нь мэдээгүй. Өмнө нь өдөж шоглосон хөвгүүдийг багшдаа хэлэхэд загнаад өнгөрдөг ба үүний үр дүнд нөхцөл байдал өөрчлөгдөөгүй. Нэг удаа багш нь өдөж, шоглосон хүүд арга хэмжээ аваагүй хэрнээ “хичээл үймүүлээ” гэж охиныг алгадаж байсан бөгөөд дүнгээр боох вий гэж айгаад сургуулийн удирдлагад энэ тухай хэлээгүй.

**Үр дагавар:** Өсвөр насны охиныг ангийн хөвгүүд нь өдөж шоглох явдал байнга гардаг учир охин хичээлдээ төвлөрч чаддаггүй. Дүн нь буурч, тэтгэлэггүй болох вий гэдэгт санаа зовж байгаа.



## Кейс 5:

Нэг жилийн өмнө МСҮТ-д хотын захын дүүргээс ирж суралцсан хүүхэд “Би Баянхошуунд атаман байсан” гэж бусдыг хэл амаар доромжлох, архи тамхи хэрэглэх, ангийнхнаа уруу татах, яс үндсээр ялгаварлах үйлдлүүд гаргаж байжээ. Тэрээр ангийнхнаа эрэгтэй хүүхдүүдийн дунд худлаа ярьж, ангиа казах, монголоор нь талцуулан хооронд нь зөрчилдүүлсэн учир сургуулиас хассан.

**Шалтгаан:** Ангийнхныхаа дунд нөлөөтэй болж, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн тулд хүүхэд бусдыг дээрэлхэх, өдөх үйлдэл гаргасан. Өөрийгөө бусдад сайн талаас танилцуулах, удирдан манлайлах, эв зүйгээр нийгмийн харилцаагаа удирдах зэрэг нийгмийн үр чадвар дутсан байх магадлалтай.

**Авсан арга хэмжээ:** Сургуулийн захиргаа ээжийг нь дуудан уулзаж, хүүхэдтэйгээ ажиллахыг хэд хэдэн удаа сануулсан. Гэвч тухайн хүүхдийн зан байдал засрахгүй, аав ээжийгээ хүртэл дээрэлхэх хандлагатай байсан учир сургуулиас гаргасан.

**Үр дагавар:** Сургуулийн зүгээс яаралтай арга хэмжээ авч үндэстэн хоорондын ялгаа гаргах явдлыг таслан зогсоосон гэж буй боловч “Монголчууд ирж байхад казакууд дуугүй бай” гэх зэргээр дээрэлхэх байдал арилаагүй байгаа нь ярилцлагаар гарч ирсэн.

## Кейс 6:

Өнгөрсөн жил 50-60 залуу хүнгүй, зэлүүд газар цугларч бүлэглэсэн зодоон хийх дөхжээ. Үүнд 14 настай хүү оролцсон байна.

**Шалтгаан:** 14 настай хүү найзуудтайгаа сагс тоглож байхад нь өөр хорооныхон машинтай ирж хамт тоглосон. Нөгөө тал нь хожигдсондоо уурлаад, муудалцаж байх үед өөр нэг найз нь ирсэн. Муудалцаж байсан хүмүүсийн дунд өмнө нь найзыг нь зодож толгойг нь хагалж, хөлийг нь гэмтээсэн хүн байжээ. Өнгөрсөн энэ явдал сөхөгдөж, талууд маргааш нь уулзаж учраа олохоор тохиролцоод гурван талаасаа хашаатай, зугтах боломжгүй, хүнгүй зэлүүд газрыг товлосон байна. Товлосон өдөр нь 50-60 залуу цугласан ба нэг тал нь тоогоор илүү боловч хүүхдүүд, нөгөө талд нь цөөн боловч сургууль төгссөн, ажил хийдэг залуучууд цугларсан байна. Зодолдох гэсэн боловч хоёр талын нэртэй атаманууд хоорондоо танил байж таарсан учир болсон явдлыг яриулж тодруулан, цус гаргахгүй байхаар тохирч эвлэрэхээр шийдсэн. Харин хүүгийн найз өмнө нь зодуулсан учир хүүгийн талыг “хохиролтой” гэж үзэн нөгөө талын хүмүүсийг нэг нэг элэгдэж асуудлыг шийдээд, зодоонгүйгээр төгсгөжээ.

**Авсан арга хэмжээ:** Энэ явдлыг насанд хүрсэн бусад хүмүүст мэдэгдэлгүй, нууцлаад өнгөрсөн байна.

**Үр дагавар:** Хэдийгээр энэ тохиолдолд зодоон болоогүй, ноцтой шүүд хор уршиг гараагүй ч олноор цугларч асуудлыг хүчирхийллийн аргаар шийдэх оролдлого, энэ байдлыг хоёр талын “атаман” ярьж тохирон шийдэж өгч байгаа байдал, хохирлыг барагдуулах үүднээс оролцогчдын хувьд шударга юм шиг харагдах ч хүчирхийллийн арга хэрэглэж байгаа зэрэг нь анхаарал татаж байна. Энэ нь нэг талаас атаман болж бусдад эрх мэдлээ харуулах сэдэл болох, нөгөө талаас шударга бус явдлыг хүчирхийллээр шийдэх аргад сургаж байгаагаараа ноцтой. Хүүхдүүд “ер нь энэ бол байдаг л зүйл шүү дээ” гэж хандаж байгаа, энэ үйл явдал оролцсоноороо бахархаж байгаа байдал ажиглагдсан.

**Кейс 7:**

Хоёр жилийн өмнө 9-р ангийн хоёр бүлгийн охидууд муудалцаж, ангиараа сургуулийн ард уулзаад, зодолдож чаддаг нэг нэг хүүхдээ гаргаад зодолдуулсан. Сурагчийн хэлж буйгаар “Тэгэхэд аймаар зодоон” болсон байна.

**Шалтгаан:** Коридорт явж байхдаа нэгнийгээ мөрлөсөн бөгөөд олон хоног хоорондоо хэрэлдэж, сүүлдээ зодолдохоор тохиролцсон байна.

**Авсан арга хэмжээ:** Сургуулийн сургалтын менежер мэдсэн бөгөөд цагдаа дуудаж арга хэмжээ авсан учир эдгээр хүүхдийн хооронд дахин ийм явдал гараагүй.

**Кейс 8:**

Бидний судалгаа явуулж байх үеэр урлагийн үзлэгийн дараа нэг хүүг 6-8 хүүхэд нийлээд зодсон тохиолдол гарсан.

**Шалтгаан:** Тэмцээний дараа гарсан маргаанаас болсон гэж зодуулсан хүүхдийн ээж хэлж байв. Өмнөх өдөр нь хэдэн хүүхэд зодуулсан хүүхдийн ангийн даргатай сургуулийн үүдэнд муудалцаад зогсож байхад нь хүү салгаад явуулжээ. Ангийн дарга гэртээ харихаар явахад муудалцсан хүүхдүүд араас нь дагаж, гэрийнх нь ойролцоо очиж байгаад зодсон. Ангийн даргыг яагаад ингэж зодсоныг нөгөө хүүхдүүдээс асуух гэж байгаад хүү өөрөө зодуулсан гэж ээж яриу. Хүүхдийн байцаагчаас тодруулахад зодуулсан хүүхэд өмнө нь хэл амаар доромжилж, мөрлөж, дээрэлхдэг байсан ба нэг хүүхэд хариугаа авахаар найзуудаа дуудаж, дээрэлхсэн хүүхдийг бүлэглэн зодсон байдал илэрсэн. Хүүхдүүдийн эцэг эх, багш нар энэ талаар мэдээлэлгүй байсан.

**Авсан арга хэмжээ:** Өмнөх өдөр зодуулсан хүүхдийн аав цагдаад хандсан бөгөөд айлгахын тулд цагдаад хандсаар байгаа ба хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй байна. Энэ тохиолдлын дараа сургуулийн нийгмийн ажилтан эцэг эхийг дуудаж уулзсан.

**Үр дагавар:** Өмнөх өдөр нь зодуулсан хүүхэд хүнд бэртэж, эмнэлэгт эмчлүүлжээ. Харин зодуулсан 2 дахь хүүхэд буюу өөрөө дээрэлхсэний хариуд зодуулсан гэж байгаа хүүхэд хэд хоног хичээлдээ явалгүй гэрээр эмчлүүлсэн. Энэ явдлаас хойш 21 хоногийн дараа эргэж холбогдоход дахин давтагдаагүй байв. Харин бүлэглэн хүн зодож, гэмтэл учруулсан учраас зодсон хүүхдүүд эрүүгийн хариуцлага хүлээж болзошгүй байдалд байна.

## Кейс 9:

Зуны амралтын үеэр охид гудамжинд сагс тоглож байгаад муудалцаж, хоорондоо зодолдсон. Нэг тал нь дүүрэгтээ шилдэг гэж танигдсан сагсан бөмбөгийн баг байжээ. Охид маажих, үс зулгаах, нүүр лүү цохих зэргээр ширүүн зодолдсон бөгөөд нэг охин нь хүнд гэмтэл авсан байна.

**Шалтгаан:** Сагс тоглож байгаад ялимгүй зүйлээс болж муудалцсан.

**Авсан арга хэмжээ:** Энэ зодооныг насанд хүрэгчид, хүүхдийн байцаагч мэдэж, мэдүүлэг авсан. Талуудад сануулах арга хэмжээ авч, эцэг эхэд нь хэлсэн.

**Үр дагавар:** Зодуулсан охин хүнд гэмтэл авч, нүдэнд харагдахуйц том сорвитой болсон. Үүний үлмаас байнга хоолойтой цамц өмсч явдагтаа их бухимддаг, өс санадаг. Одоо ч гэсэн зодолдсон талууд хоорондоо зөрчилдөөнтэй байдаг.

## Кейс 10:

МСҮТ-эд сурахаар Багануураас ирж, дотуур байранд амьдарч байсан залуу өмнө нь хүн амины хэрэгт сэжиглэгдэж байгаад байцаалтын үеэр зугтаасан байсныг сургууль, дотуур байрны ажилтнууд мэдээгүй. Хүүхдүүдийн гайгүй хувцсыг дээрэмдэж авсан, мөнгө нэхдэг тул хүүхдүүд мөнгөгүй явдаг болсонд тэр хүүхдийг сэжиглэж байгаа ч том биетэй биш, хүүхэд дээрэлхэж байгаа нь харагддаггүй байсан учраас багш нар ажиглаагүй, одоо баримт нотолгоо байхгүй. Бусад хүүхдүүд юу ч хэлэхгүй байгаа учир нотолж чадахгүй байжээ.

**Авсан арга хэмжээ:** Багш нар ээлжлэн дотуур байранд шөнөөр ажиллаж эхэлжээ. Шөнийн 4 цагт гэнэтийн шалгалт хийхэд гаднаас хоёр гурван хүүхэд оруулаад, нэг өрөөний хэдэн хүүхдийг коридорт хөөж гаргаад, өрөөнд нь унтаж байсан ба хүүхдийн хувцас, мөнгийг нь булааж авсан байсан. Цагдаа дуудаж нөгөө хүүхдийг барьж өгсөн. Одоо энэ сургуулийн дотуур байр 3 ээлжийн, 24 цагийн багштай болсон.

**Үр дагавар:** Сургуулийн зүгээс хүүхдээ судлаагүй, хариуцлагагүй байдал гаргасан. Хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн, сэжиглэгдсэн хүүхэд сургуульд сурах эрхтэй ч хяналт, хүмүүжлийн арга хэмжээ, дотуур байранд насанд хүрсэн хүний хараа хяналт дутмаг байсныг энэ үйл явдал илрүүлсэн. Энэ хүүхдийн үйлдлийн үлмаас бусад хүүхэд хувцасгүй, мөнгөгүй болж, сэтгэл санааны дарамт, айдас, түгшүүртэй болж, сурлага нь муудсан байна. Гэвч хүүхдүүд багш нартаа хэлээгүй учир цаг хугацаа их алдсан, айдас түгшүүртэй нөхцөлд удаан хугацаанд амьдарсан байна.

Тодорхой кейсээр баталгаажуулж чадаагүй ч бүлгийн ярилцлагын явцад дурдагдсан бусад тохиолдлыг тоймлон танилцуулья.

- *Бие махбодийн халдлага* зодох, цохих, алгадах, дэгээдэх, мөрлөх гэсэн үйлдлээр илэрдэг. Эдгээрээс хамгийн түгээмэл тохиолддог үйлдэл бол зөрж өнгөрөхдөө “санаатайгаар мөрлөх” явдал юм.
- *Сэтгэлзүйн дарамт үзүүлэх нь* мөнгө нэхэх, тамхинд гүйлгэх, тамхи татахыг шаардах, цүнхээ үүрүүлэх, анги цэвэрлүүлэх, нууцыг нь задална гэх зэргээр сүрдүүлэх байдлаар илэрдэг байна.
- *Ам хэлээр доромжилж, дарамтлах нь* биеийн хэлбэр, гадаад үзэмж зэргээр нь хочлох, доромжлох, мөн нэр хүндэд нь халдсан цуу үг тараах байдлаар илэрдэг. Жишээлбэл, охидын хувьд бэлгийн замбараагүй амьдралтай, жирэмсэн болсон, бэлгийн харьцаанд орсон, биеэ үнэлдэг зэрэг цуу үгийн бай болох нь түгээмэл байдаг. Хөвгүүдийн тухайд “бусдад зодуулсан” гэсэн цуурхал их гардаг.
- ЕБС, МСҮТ-ийн хүүхдүүд насны хувьд ойролцоо боловч хамтран үйл ажиллагаанд оролцдоггүй, бүр социализмын үеэс тогтсон сурлага муутай, хэрэг тарьдаг хүүхэд МСҮТ-д ордог гэсэн нийгмийн сөрөг хандлага арилаагүйн нөлөөгөөр ЕБС-ийнхэн МСҮТ-ийн хүүхдүүдийг “тэнэг мангарын сургууль,” “шилмэл тэнэгийн сургууль” гэх зэргээр нэр хоч өгч өддөг. Улмаар сургуулиараа талцан зодолдох, маргалдах тохиолдлууд гарсан.
- Хичээл эхлэх 9 сард ялангуяа МСҮТ дээр шинэ хамт олон бүрэлдэж байгаатай холбоотойгоор, мөн хонхны баярын үеэр архины хэрэглээтэй холбоотойгоор залуусын дунд зодоон гарах нь их байдаг.
- МСҮТ-ийн оюутнууд 70 мянган төгрөгийн тэтгэлэг авдаг бөгөөд мөнгө буусан өдөр төв АТМ-ийн хавиар бусад сургуулийн хүүхэд, насанд хүрэгчид МСҮТ-ийн оюутныг хүлээж байдаг. Сургуулийн зүгээс тэтгэлэг буух үед цагдаад мэдээлэл өгч, ямар нэгэн халдлагаас урьдчилан сэргийлж ажиллаж байгаа нь сайн үр дүнд хүрч байгаа боловч бүрэн зогсоож чадаагүй байна.
- *Фэйсбүүкээр дарамтлах* явдал гардаг байна. Нэрээ нууцалж, худал нэр зохиож юмуу бүр тухайн хүүхдийн нэрээр хуурамч хуудас нээж ороод, бусдыг үг хэлээр доромжлох, таагүй тэмдэглэл үлдээх, өөр хүнийг өдөж муудалцах зэрэг асуудал тохиолдож байна.

Ийнхүү хүүхдүүд бие биеэ дээрэлхэж буй байдал ялангуяа, сэтгэлзүйн болон үгэн хэлбэрээр дарамтлах асуудлууд багш, эцэг эх, нийгмийн ажилтанд мэдэгдэлгүй өнгөрөх нь түгээмэл байна. Мэдэгдсэн тохиолдлуудыг авч үзвэл гэмтсэн, нүүр ам нь хөхөрсөн, үйлдэл дээр нь барьсан, тун цөөн тохиолдолд хүүхэд өөрөө хандсан асуудлыг мэдэж шийдвэрлэж байна.

Хүчирхийлэлтэй нүүр тулсан залуус хичээлдээ явах хүсэлгүй болох, гадуур сэлгүүцэх, сургууль завсардахад хүрч байна. Мөн сэтгэл санааны хувьд маш хүнд байдалд орж, улмаар сэтгэцийн эрүүл мэндийн хувьд ноцтой байдалд орж байснаа ярилцлагын үеэр хүүхдүүд ярьж байна. *“Амиа хорлохыг оролдож, судсаа ханаж үзсэн,” “Зодооны улмаас хэсэг зуур ой санамжаа алдаж байсан,” “Өөрийгөө зүсэж байж тайвширдаг болсон”* жишээ байна.

Нөгөө талаас, үр дагаврыг бодолгүй тухайн үеийн сэтгэл хөдлөлдөө автан гаргасан шийдвэр нь залуусын хэн нэгнийг гэмт хэрэгтэн болгож шүүх, цагдаагаар асуудлаа шийдвэрлүүлж, амьдралдаа хар толботой үлдэж, нөгөө нь бие махбодь, сэтгэл санаа, амь насаараа хохирох хүнд үр дагаварт хүргэж болохоор байна.

Хүчирхийлэл бол залуу хүний үгийн мөн чанар биш. 15-24 насанд хүний хөгжлийн онцлог нь бие, сэтгэхүйн хөгжлийн зэрэгцээ нийгэмдээ үнэлэгдэх, орчин хүрээлэлдээ хүлээн зөвшөөрөгдөх, аливаад бие даан оролцож чадахаа харуулах эрмэлзэл байдаг. Энэ үед орчин тойрны бусад хүн, ялангуяа үе тэнгийнхэндээ бие даасан, эрх мэдэлтэй, хүчтэй байгаагаа харуулах нь чухал болж ирдэг ба үүнийгээ батлахын тулд хүчирхийлэл үйлдэх магадлалтай. Хүчирхийлэл гарч байгаа нь өнөөгийн залуус хүмүүжилгүй болсонтой холбоотой бус харин амьдралд нь тохиолдож байгаа зөрчил, асуудлыг шийдэх арга зам хайж байгаа хэрэг юм. Гэтэл өмнөх хэсгээ санах юм бол хүчирхийлэл нь зөрчил, асуудлыг шийдэх нийгмээс сурсан зан үйл бөгөөд нийгмийн танин мэдэхүйн онол (А.Бандура)<sup>16</sup>-оор бол хүн бусдын зан үйлийг ажиглах замаар өөрийн зан үйлийг зохицуулахад суралцдаг юм. Тиймээс хүүхэд залуучууддаа зөрчлийг шийдэх хүчирхийлэлгүй арга замыг зааж сурган, хүчирхийлэл гарсан тохиолдолд таслан зогсоох шийдвэртэй арга хэмжээ авч байхын зэрэгцээ гэр бүл, орчин тойронд нь асуудлыг хүчирхийлэлгүй шийдэж үлгэр дуурайлал болох нь насанд хүрэгсдийн үүрэг, хариуцлага болж байна.

<sup>16</sup> Албан бус орчуулга. Дэлгэрэнгүйг дараах линкээс үзнэ үү. [http://www.jku.at/org/content/e54521/e54528/e54529/e178059/Bandura\\_SocialLearningTheory\\_ger.pdf](http://www.jku.at/org/content/e54521/e54528/e54529/e178059/Bandura_SocialLearningTheory_ger.pdf)

Гуравдугаар бүлэг

Залуучуудын дундах хүчирхийллийн  
илрэх хэлбэр, нийтлэг шалтгаан



Өмнөх бүлгээс дүгнэхэд, залуу үеийн эхлэл болох өсвөр насанд нийгмийн харилцааны орчинд хүндрэлтэй асуудал үүсэхэд хүчирхийлэл гаргах явдал багагүй байна. Сургууль, дотуур байр, сагсны талбай гээд олон нийтийн газар эхэлсэн зөрчил лавширч, хүний нүднээс далд эзгүй талбай, сургуулийн арын хоосон газарт урьдчилан товлож, аль аль талаасаа баг, бүлэг бүрдүүлэн ирж зодолдон нэгнээ гэмтээж бэртээх, шарх сорви суулгах, зарим нь эрүүгийн хариуцлага хүлээх байдалд орсон явдал ч гарсан байна.

Сэдэл, шалтгаан нь янз бүр. Өмнө нь зодуулж дээрэлхүүлсэндээ өс санан хариугаа авах зорилгоор, бусдын өдөөн хатгалтад тэвчээр алдарсан учраас, тоглоод хожигдсон юмуу дээрэнгүй хандсан гэж санагдаж байсан учраас, бусдад зодуулж дээрэлхүүлсэн хамаатан, найз нөхдөө өмөөрөх үүднээс хүчирхийлэл үйлджээ. Санамсаргүй багахан зөрчил ч бүлгийн томоохон зодоонд хүргэж, хүүхдийн эрүүл мэндэд хор хохирол учруулсан явдал гарчээ.

Сонирхолтой нь сагс, урлагийн үзлэг зэрэг өрсөлдөөнт спортын үеэр хожигдсон тал шалтаг хайж зодоон үүсгэсэн байна. Энэ нь тохиолдлын шинжтэй байж болох ч сагсны талбай дээр, сагс тоглох үеэр өөр өөр анги, сургууль, хорооны хүүхдүүд хамтдаа байх нөхцөл, боломж гардагтай холбоотой байх магадлалтай. Налайх дүүргийн хувьд ЕБС, МСҮТ-д сурдаг ойролцоо насны хүүхдүүд нийлж найзалдаггүй, хамтран ажилладаггүй нь талцал, сургуулиараа хуваагдаж зодолдох нөхцөл болдог байна. Дэлхийн бусад орны туршлагаас харахад өсвөр насныхныг хамтран болон багаар ажиллахад сургах, зөрчлийг эвээр шийдэх амьдрах ухааны аргуудад сургах нь хүчирхийлэл гарахаас сэргийлэх чухал стратеги гэж үзэн зохион байгуулалтын хувьд нэг орон нутгийн залуучуудыг харьяа сургуулиар нь хагаралдуулахгүйн тулд орон нутгийн зүгээс чөлөөт цагийн хөтөлбөр, залуучуудын хөдөлгөөн зохион байгуулж, бүх хүнийг хамруулахыг хичээдэг байна. Ийм хөтөлбөр одоогоор Монголд хэрэгжихгүй байгаа.

Өсвөр насны хүүхдүүдийн дунд хүчирхийллийг өөгшүүлэх соёлын шинжтэй цөөн хэдэн зүйл ажиглагдлаа. Хөвгүүд, охидын аль алинд нь ямар нэгэн асуудал тулгарвал хамгаалах “ар талын хүч”-дээ ханддаг байна. Энэ үүргийг ихэнхдээ “дээд ангийн ах/эгч,” “хамаатны ах/эгч,” “найзууд” эсвэл “бусдад танигдсан бүлэг буюу атаман” гүйцэтгэдэг. Хэнд, ямар ар байгааг ам дамжуулан ярьдаг. “Атаманууд” нь дүү хүүхдийн “ар” болохоос гадна бас тодорхой бүлгийн эрх ашгийг төлөөлж хэлэлцээ хийх, гомдолтой талын гомдлыг барагдуулах шийдвэр гаргаж бусад нь энэ шийдвэрийг даган мөрдөж байна. Мөн “сайн зодолддог” гэсэн нэр тун чухал аж. “Ар сайтай,” “сайн зодолддог,” “олон танилтай” хүүхэд тэр бүр дээрэлхүүлдэггүй байна. Энэ насны хүүхэд, залуус, ялангуяа хөвгүүдэд “манай тал” гэдэг ойлголт чухал түл “танилын хүрээ” сайтай байх, тухайн орон нутгийн уугуул байх нь зөрчлөөс зугтах, зайлсхийх боломж олгодог ба энэ нь өөр орон нутаг, ялангуяа хотоос шилжин ирсэн хөвгүүдийн хувьд дээрэлхэлтийн бай болох эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Анхаарал татсан өөр нэг асуудал бол хүчирхийлэл гарсан тохиолдолд шийдвэрлэж байгаа арга зам юм. Энэ нь нэг талаас тухайн тохиолдлыг таслан зогсоох, нөгөө талаас давтагдахаар сэргийлэх зорилготой байх ёстой. Харамсалтай нь, манайд ийм арга хэмжээ хангалтгүй, байгаа нэг нь үр нөлөө муутай байна. Уг нь багш, эцэг эх, нийгмийн ажилтан оролцсон тохиолдолд зөрчил үргэлжлэхгүй намжих хандлага бий. Гагцхүү багш нар хүмүүжлийн уламжлалт арга хэмжээ болох сануулаад орхих, нэг хэлээд орхих зэргээр асуудлыг түүштай шийдвэрлэхгүй орхиж байна. Ангийн багшийн үгэнд орохгүй бол захирал оролцдог туршлага байгаа ч сургуулийн захирал хүүхэд хүмүүжүүлэх ажилд оролцсон тохиолдол таарсангүй. Асуудал гарсан тухай нийгмийн ажилтан, сургуулийн захиргаа мэдвэл ангийн, багшийн нэр хүнд, ажлын үнэлгээнд сөргөөр нөлөөлөх учир анги дотроо загнах, зэмлэх, учирлаж ярилцах арга хэмжээ авдаг. Ингээд үр дүнд хүрэхгүй бол эцэг эхийг нь дуудаж мэдэгдэх, нийгмийн ажилтанд асуудлаа шилжүүлж арга хэмжээ авахуулдаг ч томчууд түүштай хамтран ажиллахгүй байна. Сургуулийн зүгээс “мэдэгдэл, анхааруулах хуудас өгөх,” “сургуулиас хөөхийг сануулах” гэсэн нийтлэг арга хэмжээг авч байна.

Ер нь ноцтой асуудал үүссэн тохиолдол хүүхдийн хүмүүжлийн асуудалд анхааран хамтран ажиллахын оронд сургуулиас хөөх, шилжүүлэх зэргээр өөрсдөөсөө холдуулж, зайлуулах хандлага байна. Түүнчлэн эцэг, эхчүүд асуудал гаргасан хүүхдийг айлгах зорилгоор цагдаад өргөдөл гаргаж байгаа ч үнэхээр ойлгуулах, өөр арга хандлагад сургах зорилго, утга агуулгатай үйл ажиллагаа явагдахгүй байна. Насанд хүрэгчид болсон явдлыг мэдэхгүй өнгөрөх явдал түгээмэл байна. Насанд хүрэгчдийн зүгээс юуны түрүүнд хүүхэд, залуусыг буруутгах хандлагатай байдаг, харилцааны соёлгүй, гэр бүлдээ гаргадаг зангаа энд гаргалаа, одоогийн хүүхдүүд замбараагүй болсон гэх мэтээр шүүмжилж ханддаг учир асуудлаа нууцлах сонголтыг хийж байна. Нөгөө талаас, өсвөр насны хүүхдийг нийгмийн харилцаанд сургах үйл ажиллагаа алга.

Урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллага сургуультай хамтран ажиллаж сурагчдыг зааланд олноор нь цуглуулж мэдээлэл өгөх ажил хийгдэж байна. Гэтэл сурагчид “Урдуур суусан нь аргагүйн эрхэнд сонсдог, араар суусан нь гар утсаараа оролдоод өнгөрдөг” гэж энэ ажлыг дүгнэж байна. Тиймээс мэдээлэл өгөхөөс гадна байнгын, тасралтгүй мэдээллийн орчинд амьдарч байгаа залуучуудын хэрэгцээ, сонирхолд нийцсэн үйл ажиллагаа, арга хэлбэр шаардлагатай байна.



Дөрөвдүгээр бүлэг

Хүчирхийлэл гарахад нөлөөлж буй  
эрсдэлт хүчин зүйлсийн дүн шинжилгээ



### Хувь хүний түвшинд

Судалгааны кейсүүдээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, өөр газраас шилжин ирэгсэд, жижиг биетэй, даруухан, сул дорой гэж харагддаг, ядуу айлын болон гэр бүлийн анхаарал сул хүүхэд дээрэлхүүлэх, байнгын дарамтад өртөх магадлал их байна.

### Гэр бүлийн түвшинд

Дээрэлхүүлж буй болон дээрэлхэж буй хүүхдийн хувьд гэр бүл нь тогтворгүй, гэр бүлийн зүгээс хүүхдэд тавих анхаарал сул нийтлэг хүчин зүйл илэрч байна. Эцэг эх нь салсан, хойд эцэг эхтэйгээ таарамж муутай, эцэг эх нь архины хамааралтай, амьдралын боломж доогуур, ажлын шаардлагаар олон хоногоор гэртээ байдаггүй тохиолдлууд энэ судалгааны явцад тохиолдож байв. Асуудал гараад сургууль дээр дуудагдах юм бол эцэг эхчүүд хүүхдийнхээ талд орж хүүхдээ зөвтгөх, бусдыг буруутгах (зарим эцэг эх хүүхдээ зодууллаа гэвэл эргээд нөгөө хүүхдийг нь зодсон тохиолдол гарсан), ингэснээр хүчирхийллийн аргаар асуудлыг шийдэх үлгэр үзүүлж буруу зан үйлийг нь өөгшүүлэх, эсвэл бүр тоохгүй өнгөрөх явдал ч байна. Хүүхэд нь зодоон хийсэн хэргээр сургууль дээр дуудагдаж, нийгмийн ажилтантай үулзсан ээж “Зодоон хийгээд байхдаа яадаг юм. Тийм бол нүдэнд харагдахгүй газар нь цохихгүй...” гэж зэмлэсэн тохиолдол гарч байжээ.

### Орчин хүрээллийн түвшинд

Судалгаанд оролцогчид, ялангуяа насанд хүрэгчид орон нутгийн онцлогоос болж залуу хүмүүс хүчирхийлэл үйлдэж, нэгнийгээ дээрэлхдэг гэж үзэх нь их байлаа. Тухайлбал, тус дүүрэгт архидалт, ажилгүйдэл, ядуурал, баян хоосны ялгаа ихтэй, хүн амын хувьд ажилчин анги ихэнхийг нь бүрдүүлдэг учир боловсролын түвшин доогуур зэрэг хүчин зүйлс хүүхэд, залууст нөлөөлдөг гэж тайлбарлаж байна. Эдгээр нь зарим талаар нөлөөлж байж болох ч судлаачдын зүгээс дараах шалтгаануудыг анхаарах хэрэгтэй гэж дүгнэж байна. Үүнд:

- Өсвөр насныхан, залуу хүмүүсийг нэгдэж нийлэх, нэг хамт олон болоход туслах. Залуучуудыг идэвхжүүлэх, хамт олныг бэхжүүлэх арга хэмжээ хангалтгүй байгаа нь анзаарагдаж байна. ЕБС болон МСҮТ-ийн хувьд нийтлэг зүйл нь урлагийн үзлэг, сагс, спортын тэмцээний дараа хэрүүл, зодоон гардаг явдал юм. Тэдний сонирхлыг өдөөх, чөлөөт цагийг нь зохистой өнгөрүүлэх арга хэмжээ зохион байгуулж байгаа нь сайшаалтай ч анги, сургуулиар нь талцуулан, уралдуулах арга хандлага зөв эсэхэд эргэлзэхэд хүрлээ. Нэг хоёр хүний хооронд үүссэн зөрчил нь анги, сургуулийн зөрчил болж даамжрах магадлалтай.
- Тэмцээний үеэр бөмбөг дамжуулсангүй, хөл дээр гишгэсэн, мөрлөсөн гэж бүхимдах, эсвэл хожигдсондоо уурлаж бусдыг дээрэлхэх тохиолдлууд гардаг ба ийм давтамж байсаар байтал багш нар анхаарал хандуулж, арга хэмжээ авахгүй байна.

- Залуустай хийсэн ярилцлагаар тэд өөрийн амьдран суудаг хороондоо явахад аюулгүй байдаг бөгөөд өөр хороогоор явахад өдөх, дээрэлхэх гэж оролдох, бүлэглэн зодох зэрэг асуудал гардаг гэж мэдээлж байна. Жишээлбэл, Өвөр шанд, Есөн тойрог, Уурхайчид, Гандангийнхан, Казахын хорооны залуус хоорондоо талцаж зодолдох, зодолдох дөхсөн тохиолдлууд ч байна.
- Хүнгүй, зэлүүд газар их байна. Томчууд халдлага, хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхдээ “камерын хяналт”-ыг бий болгочихвол энэ асуудал шийдэгдэнэ гэж үзэж байна. Залуусын яриагаар зодоон хийх, хэн нэгэнд халдах газрууд нь сургуулийн камергүй хонгил, булан, бие засах газар, гэрээс сургууль орох зам, нийтийн тоглоомын талбай байдаг ажээ. Ялангуяа бүлэг зодоон хийхээр хүнгүй, зэлүүд, зугтах боломжгүй газруудыг сонгож авдаг байна. Камержуулалт, эргүүл зэрэг нь орчны аюулгүй байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болох талтай.
- Тодорхой цаг хугацаанд зөрчил гардаг байна. Жишээлбэл, хонхны баяр, хичээл эхлэх 9 сард зодоон их гардаг байна. Харин МСҮТ-ийн хичээл эхлээд хэдэн сар болоход бие биеэ таньж, нөхөрлөдөг учир асуудал гарах нь багасдаг байна.

### Нийгмийн түвшинд:

- Жендэрийн хэвшмэл, явцуу дүр сэтгэлгээ нөлөөлж байна. Эрэгтэй хүн хүчтэй, зоригтой, дийлдэшгүй байх ёстой; эмэгтэй хүн даруу төлөв, цэвэр ариун байх ёстой гэсэн нийгэмд тогтсон энэхүү хэвшмэл ойлголт залуучуудад нөлөөлдөг байна. Улмаар эрэгтэй хүүхдийг бусдад зодуулсан, эмэгтэй хүүхдийг бэлгийн замбараагүй амьдралтай гэх цуу яриаг дээрэлхэх арга хэрэгсэл болгож ашиглах нь нийтлэг байна.
- Хүчирхийлэл нь нас, ангиар чацуутнуудын хооронд гэхээсээ дээд, доод ангийн хүүхдүүдийн хооронд гарч байна. Доод ангийнхан дээд ангийнхны үгэнд орох, үг дуугүй хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн утга санаа агуулсан энэ хэм хэмжээг өнгөрсөн жил ахлах ангийхандаа дээрээлхүүлсэн хүүхэд дараа жил нь өөрөө дээрэлхэгч болох маягаар “өвлөгдөн”, жилээс жилд давтагдах магадлалтай.
- Хүчирхийлэлтэй эвлэрсэн нийгмийн хандлага нь залуучуудад сөргөөр нөлөөлж байна. Жишээлбэл, “100 орчим залуус бүлэглэн зодолдсон хэрэг гарч байсан талаар юу мэдэх вэ, иймэрхүү зүйлс хэр их тохиолддог вэ?” гэж<sup>17</sup> асуухад цагдаагийн ажилтан “70, 80-аад онд гарч байсан хэрэгтэй андуураад байх шиг байна. Тэр үед олон хүнийг хамарсан аймаар зодоонууд гарч байсан. Одоо ингэж зодолдох шийртэй залуус байхгүй болсон” гэж хариулсан.

<sup>17</sup> Тайлбар: Анх судалгааны тандалтын үе шатанд 100 орчим залуус зодолсон тухай дурдагдсан ба судлаачид энэ тохиолдлыг баталгаажуулах, шийдвэрлэгдсэн байдлыг нь судлахыг хичээсэн.

Тавдугаар бүлэг

---

Залуучуудын дундах хүчирхийллээс  
урьдчилан сэргийлэх арга стратеги



Хүчирхийлэл бол урьдчилан сэргийлж болдог зан үйл<sup>18</sup> бөгөөд хувь хүн, гэр бүл, орчин хүрээлэл, нийгмийн зүгээс хүчирхийлэл гарахад нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлснээр зан үйлийг өөрчилж, улмаар хүчирхийлэл гаргахаас нь өмнө урьдчилан сэргийлж болно. Жишээлбэл, АНУ-ын “Халамж анхаарал тавьдаг орон нутаг/олон нийт” (Communities that Care) хөтөлбөрийг хэрэгжүүлсэн 24 газарт ийм хөтөлбөргүй орон нутагтай харьцуулахад 5-7 дугаар ангийн хүүхэд, өсвөр насныхны дунд хулгайлах, бусдад халдах танхайн үйлдэл 27 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Энэ ялгаа наад зах нь 3 жилийн туршид буюу 10 дугаар ангийн түвшинд тууштай хадгалагдсан байна. Зардал үр ашгийн шинжилгээгээр 8 дугаар ангийн түвшинд нэг сурагчид ногдох байдлаар 5250 долларын хэмнэлт гарсан байжээ.<sup>19</sup>

Хүчирхийлэл гарахад нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг ойлгон, тэдгээрийн нөлөөг бууруулах арга хэмжээ боловсруулахад юуны өмнө мэдлэг хэрэгтэй. Энд нийгмийн эрүүл мэндийн салбарт ашигладаг өвчин, эндэгдлийг бууруулахад туслах хувь хүний зан үйлийн өөрчлөлт, орчны аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах арга зүй хамгийн тохиромжтой юм. Ялангуяа бие даан шийдвэр гаргах, нийгмийн харилцаагаа өөрөө зохицуулахад суралцаж байгаа өсвөр насны хүүхдүүд болон залуучуудад энэ мэдлэг, дэмжлэг нэн чухал.

Олон улсын судалгааны эх сурвалжууд залуучуудын дундах хүчирхийллийг бууруулахад 4 түвшний хүчин зүйлд анхаарахыг зөвлөж байна.

**Хувь хүний хамгаалах хүчин зүйлсэд** залуучуудыг хөгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаанд хамруулах, үр чадвар/авьяасыг хөгжүүлэхэд туслах, амжилттай сурахад нь дэмжлэг үзүүлэх, хүлээцтэй хандах, нийгмийн хэм хэмжээ, нийтийн хэв журмын талаар эерэг ойлголт, баримжаатай болоход нь туслах зорилготой стратегиуд багтана.

**Гэр бүлийн түвшний хамгаалах хүчин зүйлсэд** гэр бүлийнхэн, насанд хүрэгчидтэй холбоо харилцаатай байхад туслах, эцэг эхтэйгээ асуудлаа ярилцах, итгэл бий болгоход туслах, эцэг эхийн хүүхэдтэйгээ харилцах үр чадварыг хөгжүүлэх, эцэг эхийнхээ хамтаар оролцох үйл ажиллагаа зохион байгуулах, нийгэм/орон нутгийн амьдралд оролцуулах үйл ажиллагаа зэрэг багтана.

---

<sup>18</sup> Мөн тэнд.

<sup>19</sup> Албан бус орчуулга. David-Ferdon C, Simon TR. Taking Action to Prevent Youth Violence: A Companion Guide to Preventing Youth Violence: Opportunities for Action. Atlanta, GA: National Center for Injury Prevention and Control, CDC, 2014, 30.

**Орчин хүрээллийн түвшний хамгаалах хүчин зүйлсэд** сургууль дээр үүсэх зөрчил, сөрөг харилцааг эергээр зохицуулахад нь туслах, сайн сайхан зүйлсийг бий болгоход сургуулийн оролцоо, үүргийг нэмэгдүүлэх, үлгэр дуурайлал болох залуучуудыг алдаршуулах, сургуулийн хүүхдүүдтэй холбож өгөх, эерэг чиг баримжаатай нийгмийн бүлгүүдэд гишүүнээр элсэхэд дэмжлэг үзүүлэх, нийгэмд тустай ажил эрхлэх, санаачлан хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжих, сургуулийн удирдлагын зүгээс сөрөг үйлдэл, зөрчлийг эв дүйгээр зохицуулахад оролцдог болох, хүчирхийллээр зөрчлийг шийдэж болохгүй гэсэн байр сууриа тууштай баримтлах зэрэг багтана.

Хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх зорилгоор хуулбарлан авч хэрэгжүүлж болох зарим хөтөлбөрийн жишээг энд дурдья. АНУ-ын ӨХТ-ийн туршлагад тулгуурлан<sup>20</sup> дараах хөтөлбөр, үйл ажиллагааг явуулахыг санал болгож байна.

Орон нутаг, сургуулийн удирдлага, багш, албаны бусад хүмүүс дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно.

1. Залуу хүний нийгмийн харилцаа, өөрийн зан үйлийг хянах үр чадвар, туршлагыг дээшлүүлэхэд:
  - Сургуульд үе тэнгийн зөвлөх, сайн дурын менторын хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - Бизнес, нийгэм/иргэний бүлгүүдтэй хамтран ажиллаж, залуучуудын сонирхол, үр чадвар, авьяасыг нь хөгжүүлэх боломжуудыг өргөтгөх;
  - Залуучуудын зөв зан үйлийг урамшуулсан, багаар ажиллах (уралдаан биш) тогтмол арга хэмжээ, тодорхой тохиолдолд багш, эцэг эх, сургуулийн захиргаа, нийгмийн ажилтан нэг баг болж ажиллах замаар хүчирхийллийг таслан зогсоох, давтагдахгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах, ийм арга хэмжээний удирдамжтай болох.
2. Нийт орон нутагт үр ашгаа өгөх залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нотолгоонд суурилсан стратегийг ашиглах буюу сурталчлах:
  - Залуучуудын дундах хүчирхийллийн талаар мэдээлэл өргөнөөр тараах, ингэхдээ салбарын мэргэжилтэн, нийгмийн бүлгүүд, идэвхтэй иргэд, сайн дурын залуучуудыг дайчлан, зохион байгуулалтаар хангах;
  - Урьдчилан сэргийлэх зорилгыг нэн тэргүүнд тавьж, судалгаа, статистик мэдээлэлтэй болж, үр дүнг шийдвэр гаргалтад ашигладаг болох;

<sup>20</sup> АНУ-ын ӨХТ-ийн мэдээлэлд тулгуурлав.

- Залуучуудыг зорилтот бүлэг болгон тусад нь харж үйл ажиллагаа төлөвлөхийн зэрэгцээ гэр бүл, сургууль, орон нутгийн нийтийн үйл ажиллагаа, хөтөлбөрт нэгдсэн байдлаар хамруулахад онцгой анхаарах;
- Залуучуудын дундах хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй үйл ажиллагаа, хөтөлбөрийн тухай байгаа мэдлэгийг ашиглах, шинэ мэдлэг, мэдээлэл бий болгоход төсвийн боломж, бодлогын дэмжлэгийг дайчлах;
- Залуучуудын дундах хүчирхийлэл нь урьдчилан сэргийлж болдог нийгмийн эрүүл мэндийн асуудал гэсэн ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, энэ чиглэлд гарч буй амжилт, дэвшлийг сурталчлах.

*Гэр бүл, асран хамгаалагч, бусад насанд хүрэгчдэд хандсан дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:*

- Хүчирхийллийн бүс хариу үзүүлж болдгийг тууштай үлгэрлэх;
- Залуу хүмүүст нийгмийн хэв журам, нийгмийн хэм хэмжээг ойлгоход туслах, ингэхдээ хамтран ажиллах, зөвлөх арга замыг сонгох;
- Өсвөр насны хүүхэд, залуучуудтай итгэлцлийн харилцаа бий болгох, ярилцдаг болох.

Эдгээр нь дэлхийн бусад улс орон хэрэгжүүлж байгаа олон хөтөлбөр, үйл ажиллагааны цөөн хэдэн жишээ юм. Цаашид энэ чиглэлээр бидний өөрийн, дотоодын туршлага, мэдээ, баримт нэмэгдэнэ гэж найдаж байна.

## Ашигласан материал

Эрүүл мэндийн яам болон АНУ-ын ӨХТ “Дэлхий дахины сургууль суурилсан эрүүл мэндийн судалгаа – Монгол 2010: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийн зан үйлийг тодорхойлох.” (Улаанбаатар хот, 2011 он)

ХАХНХЯ, НҮБ-ын хүн амын сан, “Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогын зөвлөмж.” (Улаанбаатар хот, 2013 он)

БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сан болон бусад “Сургууль, цэцэрлэгийн орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, түүнийг арилгах арга зам” судалгааны тайлан. (Улаанбаатар хот, 2007 он)

“2010 оны Хүн ам, орон сууцны тооллого.” (Улаанбаатар хот, 2011 он)

Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, “Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа – 2014.”

Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, судалгааны төв, “Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам.” (Улаанбаатар хот, 2011 он)

С.Энхтуяа, “Хүүхэд хамгааллын үндэс.” (Улаанбаатар, 2009 он)

НҮБ-ийн Хүүхдийн сан, “Хууль зөрчсөн хүүхдийн асуудал Монголд” үнэлгээний тайлан. (Улаанбаатар хот, 2002 он)

David-Ferdon C, Simon TR. Taking Action to Prevent Youth Violence: A Companion Guide to Preventing Youth Violence: Opportunities for Action. Atlanta, GA: National Center for Injury Prevention and Control, CDC,

World Health Organization, “Preventing Violence and Reducing Its Impact: How Development Agencies Can Help” flyer: <http://www.who.int/violenceprevention/publications/Flyer.pdf?ua=1>

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, “Хүчирхийлэл ба эрүүл мэнд дэлхийн тайлан” <http://www.who.int/mediacentre/factsheets/fs356/en/>

<http://www.who.int/violenceprevention/approach/definition/en/>

CDC “Understanding Youth Violence” Fact Sheet, 2012

[http://www.jku.at/org/content/e54521/e54528/e54529/e178059/Bandura\\_SocialLearningTheory\\_ger.pdf](http://www.jku.at/org/content/e54521/e54528/e54529/e178059/Bandura_SocialLearningTheory_ger.pdf)

CDC “Preventing Youth Violence: Opportunities for Action” (June 2014) [www.cdc.gov](http://www.cdc.gov)